**УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** УВА-2023/30/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаангом хот<br>2023 он | Увс аймаг дахь Төрийн аудитын газар,<br>Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь<br>Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn<br>Аудитын менежер: М.Бат-Амгалан<br>Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn<br>Аудитор: Ч.Мөнхтогтох<br>Утас: 70453721, Цахим хаяг: Munkhtogtokhch@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

2023.02.24 № УВА-2023/30/НА-СТА-ТШЗ
танай ______________ -ны № ________________ -т

УВС АЙМГИЙН БАЙГАЛЬ
ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ГАЗРЫН ДАРГА Б.ЭНХТУЯА
ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Увс аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Увс аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой, санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

**Аудитын гол асуудал**

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

**Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

0200000577

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.БАТСУУРЬ

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ..... 3
Дүгнэлтийн үндэслэл ..... 3
Асуудлыг онцолсон хэсэг ..... 3
Аудитын гол асуудал ..... 3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ..... 5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА ..... 3
4.1 Ерөнхий зүйл ..... 14
4.2 Материаллаг байдал ..... 14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ..... 14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..... 15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ..... 15
4.5.1 Завсрын аудитын талаар ..... 15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ..... 15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ ..... 15

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| НА | Нийцлийн аудит |

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **31,865,742.80** | **64,480,942.80** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 31,865,742.80 | 64,480,942.80 |
| **354** | **Хангамжийн материал** | 31,865,742.80 | 64,480,942.80 |
| 35420 | Аж ахуйн материал | 11,265,100.00 | 26,151,100.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 20,600,642.80 | 38,329,842.80 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **109,340,629.42** | **242,251,267.59** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 109,340,629.42 | 242,251,267.59 |
| **392** | **Биет хөрөнгө** | 109,340,629.42 | 242,251,267.59 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 9,120,901.00 | 148,678,587.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -1,423,565.64 | -4,224,048.95 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 119,308,204.61 | 144,300,304.61 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -61,733,685.09 | -80,968,624.97 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 111,506,298.45 | 114,172,080.45 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -82,482,751.01 | -90,506,351.45 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 26,648,169.00 | 26,648,169.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -13,947,941.90 | -15,943,848.10 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 19,275,000.00 | 19,275,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -17,025,000.00 | -19,275,000.00 |
| 39217 | Ном | 95,000.00 | 95,000.00 |
| 39301 | Програм хангамж | 495,000.00 | 495,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -495,000.00 | -495,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 2,700,000.00 | 2,700,000.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | -2,700,000.00 | -2,700,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **141,206,372.22** | **306,732,210.39** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **141,206,372.22** | **306,732,210.39** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 141,206,372.22 | 306,732,210.39 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 164,179,073.38 | 164,179,073.38 |
| 51101 | Өмч: - төрийн | 164,179,073.38 | 164,179,073.38 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | -27,120,093.53 | 138,405,744.64 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -27,120,093.53 | -27,120,093.53 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 165,525,838.17 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 4,147,392.37 | 4,147,392.37 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **141,206,372.22** | **306,732,210.39** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **707,147,700.00** | **931,715,857.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **775,000.00** | **165,089,786.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 775,000.00 | 165,089,786.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 600,000.00 | 540,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 600,000.00 | 540,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **706,372,700.00** | **766,626,071.00** |

| | | | |
|---|---|---|---|
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 91,328,000.00 | 137,693,871.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 10,800,000.00 | 6,484,600.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 80,528,000.00 | 128,709,271.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 2,500,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 615,044,700.00 | 628,932,200.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 615,044,700.00 | 628,932,200.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **752,073,490.33** | **766,190,018.83** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **752,073,490.33** | **766,190,018.83** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 741,982,710.87 | 744,809,743.83 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 491,622,696.54 | 487,432,476.00 |
| 210101 | Үндсэн цалин | 491,622,696.54 | 372,924,421.00 |
| 210102 | Нэмэгдэл | 00.00 | 68,987,580.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 00.00 | 42,834,329.00 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 2,686,146.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 64,228,082.00 | 60,138,362.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 46,030,951.92 | 41,787,129.84 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,117,915.50 | 4,903,776.28 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,956,572.46 | 3,886,061.61 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 829,331.00 | 869,217.32 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,293,311.12 | 8,692,176.95 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 23,227,387.00 | 20,433,445.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,574,622.00 | 1,616,504.00 |
| 210302 | Түлш, халаалт | 17,772,480.00 | 17,772,480.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,072,285.00 | 1,044,461.00 |
| 210304 | Байрны түрээс | 2,808,000.00 | 00.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 55,416,755.00 | 32,374,161.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 5,586,500.00 | 3,558,382.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 11,471,140.00 | 21,953,676.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,467,081.00 | 1,568,295.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 6,290,000.00 | 660,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 6,262,234.00 | 4,633,808.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 24,339,800.00 | 00.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,804,200.00 | 4,202,420.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 158,000.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,646,200.00 | 4,202,420.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 13,745,800.00 | 16,888,950.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 13,745,800.00 | 16,888,950.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 3,093,760.00 | 4,588,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 819,000.00 | 2,100,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 432,000.00 | 432,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 558,750.00 | 560,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 97,010.00 | 70,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 99,000.00 | 66,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,088,000.00 | 1,360,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 87,844,030.33 | 118,751,929.83 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 42,137,500.00 | 70,752,300.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 15,820,340.00 | 13,694,700.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 29,886,190.33 | 34,304,929.83 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 10,090,779.46 | 21,380,275.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 10,060,000.00 | 13,140,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 10,060,000.00 | 13,140,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 30,779.46 | 8,240,275.00 |
| 3 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-44,925,790.33** | **165,525,838.17** |
| 5 | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-44,925,790.33** | **165,525,838.17** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **706,972,700.00** | **767,166,071.00** |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **600,000.00** | **540,000.00** |
| 120 | **Нийтлэг татварын бус орлого** | 600,000.00 | 540,000.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 600,000.00 | 540,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 600,000.00 | 540,000.00 |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **706,372,700.00** | **766,626,071.00** |
| 1311 | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 91,328,000.00 | 137,693,871.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 10,800,000.00 | 6,484,600.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 80,528,000.00 | 128,709,271.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 2,500,000.00 |
| 1320 | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 615,044,700.00 | 628,932,200.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 615,044,700.00 | 628,932,200.00 |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **706,972,700.00** | **767,166,071.00** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **706,972,700.00** | **767,166,071.00** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **696,881,920.54** | **745,785,796.00** |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 491,622,696.54 | 487,432,476.00 |
| 210101 | Үндсэн цалин | 491,622,696.54 | 372,924,421.00 |
| 210102 | Нэмэгдэл | 00.00 | 68,987,580.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 00.00 | 42,834,329.00 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 2,686,146.00 |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 64,228,082.00 | 60,138,362.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 46,030,951.92 | 41,787,129.84 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,117,915.50 | 4,903,776.28 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,956,572.46 | 3,886,061.61 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 829,331.00 | 869,217.32 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,293,311.12 | 8,692,176.95 |
| 2103 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 23,227,387.00 | 20,433,445.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,574,622.00 | 1,616,504.00 |
| 210302 | Түлш, халаалт | 17,772,480.00 | 17,772,480.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,072,285.00 | 1,044,461.00 |
| 210304 | Байрны түрээс | 2,808,000.00 | 00.00 |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | 29,386,055.00 | 47,260,161.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 5,411,500.00 | 3,558,382.00 |
| 210402 | Түлш, шатахуун | 11,471,140.00 | 21,953,676.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,467,081.00 | 1,568,295.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 4,850,000.00 | 15,546,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 6,186,334.00 | 4,633,808.00 |
| 2105 | **Нормативт зардал** | 8,729,200.00 | 3,229,200.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 8,729,200.00 | 3,229,200.00 |
| 2106 | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4,891,100.00 | 11,368,202.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 00.00 | 2,665,782.00 |
| 210602 | Тавилга | 2,244,900.00 | 00.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 00.00 | 4,500,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,646,200.00 | 4,202,420.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 13,745,800.00 | 16,888,950.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 13,745,800.00 | 16,888,950.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 3,093,760.00 | 4,588,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 819,000.00 | 2,100,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 432,000.00 | 432,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 558,750.00 | 560,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 97,010.00 | 70,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 99,000.00 | 66,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,088,000.00 | 1,360,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 57,957,840.00 | 94,447,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 42,137,500.00 | 80,752,300.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 15,820,340.00 | 13,694,700.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **10,090,779.46** | **21,380,275.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 10,060,000.00 | 13,140,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 10,060,000.00 | 13,140,000.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 30,779.46 | 8,240,275.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | **164,179,073.38** | **4,147,392.37** | **-27,120,093.53** | 141,206,372.22 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **00.00** | **00.00** | **00.00** | 00.00 |
| Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **164,179,073.38** | **4,147,392.37** | **-27,120,093.53** | 141,206,372.22 |
| **2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | **164,179,073.38** | **4,147,392.37** | **-27,120,093.53** | 141,206,372.22 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **164,179,073.38** | **4,147,392.37** | **-27,120,093.53** | 141,206,372.22 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 155,525,838.17 | 155,525,838.17 |
| **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **164,179,073.38** | **4,147,392.37** | **128,405,744.64** | 296,732,210.39 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 629,732,200.00 | 621,249,925.00 | 8,482,275.00 | 98.7 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 629,732,200.00 | 621,249,925.00 | 8,482,275.00 | 98.7 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 625,565,500.00 | 617,109,925.00 | 8,455,575.00 | 98.6 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 490,246,200.00 | 487,432,476.00 | 2,813,724.00 | 99.4 |
| 210101 | Үндсэн цалин | 370,401,400.00 | 372,924,421.00 | -2,523,021.00 | 100.7 |
| 210102 | Нэмэгдэл | 96,559,300.00 | 68,987,580.00 | 27,571,720.00 | 71.4 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 00.00 | 42,834,329.00 | - 42,834,329.00 | 0.0 |
| 210104 | Урамшуулал | 23,285,500.00 | 2,686,146.00 | 20,599,354.00 | 11.5 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 61,477,700.00 | 60,138,362.00 | 1,339,338.00 | 97.8 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 41,611,900.00 | 41,787,129.84 | -175,229.84 | 100.4 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,966,500.00 | 4,903,776.28 | 62,723.72 | 98.7 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,973,100.00 | 3,886,061.61 | 87,038.39 | 97.8 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 993,300.00 | 869,217.32 | 124,082.68 | 87.5 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,932,900.00 | 8,692,176.95 | 1,240,723.05 | 87.5 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 22,919,200.00 | 20,433,445.00 | 2,485,755.00 | 89.2 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,150,100.00 | 1,616,504.00 | 2,533,596.00 | 39.0 |
| 210302 | Түлш, халаалт | 17,772,500.00 | 17,772,480.00 | 20.00 | 100.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 996,600.00 | 1,044,461.00 | -47,861.00 | 104.8 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 14,100,100.00 | 14,099,779.00 | 321.00 | 100.0 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,670,900.00 | 2,099,300.00 | 571,600.00 | 78.6 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 9,576,100.00 | 10,132,776.00 | -556,676.00 | 105.8 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,380,400.00 | 1,568,295.00 | -187,895.00 | 113.6 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 472,700.00 | 299,408.00 | 173,292.00 | 63.3 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 10,098,300.00 | 10,094,420.00 | 3,880.00 | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 4,165,000.00 | 4,161,120.00 | 3,880.00 | 99.9 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 7,723,300.00 | 7,722,950.00 | 350.00 | 100.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 7,723,300.00 | 7,722,950.00 | 350.00 | 100.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 11783500.00 | 9971293.00 | 1,812,207.00 | 84.6 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 11,164,800.00 | 9,352,593.00 | 1,812,207.00 | 83.8 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 4166700.00 | 4140000.00 | 26,700.00 | 99.4 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 4,166,700.00 | 4,140,000.00 | 26,700.00 | 99.4 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 4,166,700.00 | 4,140,000.00 | 26,700.00 | 99.4 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 629,732,200.00 | 621,249,925.00 | 8,482,275.00 | 98.7 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 628,932,200.00 | 620,709,925.00 | 8,222,275.00 | 98.7 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 628,932,200.00 | 620,709,925.00 | 8,222,275.00 | 98.7 |
| | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 800,000.00 | 540,000.00 | 260,000.00 | 67.5 |
| | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 800,000.00 | 540,000.00 | 260,000.00 | 67.5 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлтийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **0.00** | **137,675,871.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **0.00** | **137,675,871.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | 128,675,871.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | | 33,160,382.00 |
| 210401 | Бичиг хэрэг | | 1,459,082.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | | 11,820,900.00 |
| 210404 | Ном, хэвлэл | | 15,546,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 4,334,400.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | | 1,273,782.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | 1,232,482.00 |
| 210604 | Урсгал засвар | | 41,300.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | | 9,166,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | | 9,166,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | | 600,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 600,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 0.00 | 84475707.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 71,399,707.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | 13,076,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 0.00 | 9000000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | | 9,000,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 9,000,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 0.00 | 137675871.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | 137,675,871.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | | 6,484,600.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 128,691,271.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 2,500,000.00 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Увс аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын нь Увс Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хандлагыг экосистемийн тэнцвэрт байдлыг алдагдуулахгүй байхад чиглүүлж, байгалийн нөөц баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх боломжийг бүрдүүлэх, байгальд ээлтэй тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх, ногоон хөгжлийг хангах үйл ажиллагаанд төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хамтын ажиллагааг өрнүүлж хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангахад эрхэм зорилгоо болгон ажиллаж байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, төсвийн тухай хууль, бусад хууль, тогтоомжуудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөрийн тухай хууль - Шинэчлэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль - 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан.
- ✓ Төрийн албаны тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 05-ны өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр нэмэлт өөрчлөлтүүд оруулсан байна.
- ✓ Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 01-ний өдөр, 8 дугаар сарын 29-ний өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ. Тайлант онд дотоод аудит хийгдээгүй байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Увс аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн бөгөөд байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Увс аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэлээ.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн аливаа бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 165,525.8 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0.0 | 0.0 | 0.0 |
| Авлага | 0.0 | 0.0 | 0.0 |
| Бараа материал | 31,865.7 | 64,480.9 | 32,615.2 |
| Үндсэн хөрөнгө | 109,340.6 | 242,251.2 | 132,910.6 |
| **Нийт хөрөнгө** | **141,206.4** | **306,732.2** | **165,525.8** |
| Өр төлбөр | 0.0 | 0.0 | 0.0 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 141,206.3 | 296,732.2 | **155,525.8** |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **141,206.3** | **306,732.2** | **165,525.8** |

Бараа материал дансны үлдэгдэл 64.4 мянган төгрөг болж 32.6 мянган төгрөгөөр өссөн нь бусад хангамж, аж ахуйн материал нэмэгдсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 242,251.2 мянган төгрөг болж 132,910.6 мянган төгрөгөөр өссөн нь орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгийг бүртгэж авсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 296,732.2 мянган төгрөг болж 155,525.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Энэ нь хөрөнгө өссөнтэй холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 628,932.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 181.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 629,113.5 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс орлого бүрдүүлэхээр байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 620,691,9 мянган төгрөг буюу 99.62 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 8,482.2 мянган төгрөгөөр тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Хүрээлэн буй орчны бодлого удирдлага / үндсэн үйл ажиллагаа 71411/80101 | 589,362,8 | 585,205.2 | 4,157,6 | 90,14 |
| 2 | Хүрээлэн буй орчны бодлого удирдлага 71411/80111 | 22,919,2 | 20,433,4 | 2,485,7 | 99,1 |
| 3 | Хүрээлэн буй орчны бодлого удирдлага 71411/80307 | 11,164,8 | 9,352,4 | 1,812,2 | 83,8 |
| 4 | Хүрээлэн буй орчны бодлого удирдлага 71411/80205 | 1,500,0 | 1,500,0 | | 100 |
| 5 | Хүрээлэн буй орчны бодлого удирдлага 71411/80802 | 4,166,7 | 4,140,0 | 26,7 | 99,4 |
| **ДҮН** | | **629,113,5** | **620,631** | **8,482,2** | |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 8,984.6

мянга, аймгийн Байгаль хамгаалах сангаас 128,709.2 мянга, нийт 137,693.8 мянган төгрөг бүрдүүлжээ.

Үүнээс хангамж бараа материалын зардалд 33,160.3 мянга, эд хогшил, урсгал засварын зардалд 1,273.7 мянга, томилолт зочны зардалд 9,166.0 мянга, нэг удаагийн тэтгэмж, шагналд 9,000.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 85,075.7 мянга, нийт 137,675.8 мянган төгрөг зарцуулсан байна. Нэмэлт санхүүжилтийн данснаас 18.0 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ч.Мөнхтогтох гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Байгаль орчин, аялал жуулчлалын газар нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 15 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 752,073.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Гүйцэтгэлийн үе шатанд 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 776,190.0 мянган төгрөгийн 1.0 хувь буюу 7,761.9 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 6,209.5 мянган төгрөгөөр тогтоолоо.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Байгаль орчин, аялал жуулчлалын газрын хувьд хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд биет горим сорилыг хэрэгжүүлсэн.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил гараагүй болно. /АБ-4/

## 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа байршуулсан 148 мэдээлэл, хугацаа хоцроосон 1, байршуулах хугацаа болоогүй 2 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Байгаль орчин, аялал жуулчлалын газар нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсэгт "Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй" гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

## 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.5.1 Завсрын аудитын талаар

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2022 оны хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 247.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоосныг хэрэгжүүлэн биелэлтийг ирүүлсэн байна.

## 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын хувьд дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

# 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 149,557.6 мянган төгрөгийн 2 алдаа илэрснийг аудитын явцад залруууллаа.

Үүнд: Үндсэн хөрөнгийн тайланд байгаль хамгаалах сан, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн 149,557.6 мөнгөн төгрөгийн үдсэн хөрөнгийн дутуу илэрхийлснийг аудитын явцад залруулга хийлгэв.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Үндсэн хөрөнгийн тодруулга тайлан | 2 | 149,557.6 | 2 | 149,557.6 | | | 2 | 149,557.6 | | | | |
| Дүн | 2 | 149,557.6 | 2 | 149,557.6 | | | 2 | 149,557.6 | | | | |

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН: ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН: АУДИТОР /Ч.МӨНХТОГТОХ/

2023 оны 02 дугаар сарын 25-ны өдөр